

# “ЭРЭН СУРВАЛЖЛАХ СЭТГҮҮЛ ЗҮЙН ЗАРЧИМ”

ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛЫГ САЙЖРУУЛАХ ХӨТӨЛБӨР

Сэтгүүлчдийн фокус группын сургалт  
Х.Наранжаргал, “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага

# Эрэн сурвалжлах сэтгүүл зүй

- Сэтгүүлчийн нийгэмд үйлчлэх, үнэн, шударга ёсны төлөө тэмцэх хүсэл зориг эрэн сурвалжлах сэтгүүл зүйн гол сэдлэг юм.
- Сэтгүүлчдийг алдар цуутай болгодог ,
- ХМХ-ийн хувьд нийгмийн үнэт зүйлсийг хамгаалагч эсэн алдар нэртэй болж, хэрэглэгчдийнхээ итгэлийг олж авна.

# Эрэн сурвалжлах сэтгүүл зүй

Сэтгүүл зүйн бусад төрөл зүйлээс ялгагдах онцлог:

Асуудлыг гаргаж тавих бус асуудлыг судалж шинжилдэг. Асуудлыг бүх талаас нь судалдаг

Путин: Тагнуулч, сэтгүүлч хоёрын ажил адил төстэй

# Эрэн сурвалжлах сэтгүүл зүй

- Гэмт хэрэг, эрх зүйн сэдэв нь манай нийгэм, улс төр, эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал, хуримтлагдсан суудлыг задлан шинжилж, илчилж тавьдаг тул эрэн сурвалжлах сэтгүүл зүйн салшгүй хэсэг юм.
- Туршлагагүй, мэдлэггүй хүнд эрсдэлтэй, аюултай ажил

# Эрэн сурвалжлах сэтгүүл зүй

Эрэн сурвалжлагч сэтгүүлчийн зэвсэг

- Хүмүүс мэдээллийн эх сурвалж
- Төрөл бүрийн баримт бичиг, тэдгээртэй ажиллах чадвар
- Ярилцлагыг тэвчээртэй, чадварлаг хийх
- Өндөр ёс суртахуун, нийгмийн өмнө хүлээх хариуцлагаа ухамсарлах

# Осол аваарын тухай сурвалжлага

Зайлшгүй байх мэдээлэл:

- Нас барсан, гэмтэж бэртсэн хүмүүсийн нэр, хаяг, нас
- Осол гарсан он, сар, өдөр, цаг, газар
- Осолд өртсөн тээврийн хэрэгслийн төрөл
- Ослын шалтгаан (албан ёсны эх сурвалжаас)
- Дээрх мэдээллийн эх сурвалж
- Шаардлагатай бол жолооч, хамт явсан хүмүүсийн нэр, хаяг
- Хохирогч хаана нас барсан, эсвэл гэмтэл авсан
- Гэмтэл, бэртлийн байдал
- Хохирогчийн биеийн байдал

# Осол аваарын тухай сурвалжлага

Зайлшгүй байх мэдээлэл:

- Шаардлагатай бол талийгаччийн оршуулгатай холбоотой мэдээлэл
- Осолтой холбоотойгоор хэн нэгнийг баривчилсан, эсвэл шүүхэд дуудсан

Дэлгэрэнгүй сурвалжлага хийхээр бол дараахь мэдээллийг нэмэх:

- Тээврийн хэрэгсэл аль хэр гэмтсэн
- Ямар хурдтай, ямар чиглэлээр явж байсан
- Цаг агаарын таагүй байдал, эсвэл замын байдлын тухай
- Мөрдөн байцаагч, гэрчийн мэдүүлэг

# Гал түймрийн сурвалжлага

Зайлшгүй байх мэдээлэл

- Хүн нас барсан, гэмтсэн эсэх
- Хохирогчдын тухай танилцуулга
- Гал хаана гарсан
- Гал гарсан байрны бүтэц, зохион байгуулалт
- Шалтгаан
- Мөрдөн байцаалтын явц
- Мэдээллийн эх сурвалж
- Хохирогчид хэрхэн наса барсан, гэмтэж бэртсэн

# Гал түймрийн сурвалжлага

Зайлшгүй байх мэдээлэл

- Гал хэзээ, хаана гарсан
- Галыг хэрхэн хэрхэн, хэзээ унтраасан
- Аврагчдын ажлын тухай
- Хохирогчид хаана нас барсан, эсвэл гэмтэж бэртсэн
- Гэмтэл, бэртлийн хэмжээ

# Гал түймрийн сурвалжлага

Зайлшгүй байх мэдээлэл

- Учирсан хохирол, даатгалтай эсэх
- Хэдэн гал унтраагч оролцсон, хичнээн хэмжээний ус зарцуулсан
- Гэрч, гал унтраагч, оршин суугчдын яриа
- Хүний сониохол татахуйц жижиг зүйлс
- Анх хэн дуудлага өгсөн

# Гэмт хэргийн сурвалжлага

Зайлшгүй байх мэдээлэл

- Хохирогчтой холбоотой мэдээлэл
- Ямар төрлийн гэмт хэрэг болох
- Хэрхэн, яаж үйлдэгдсэн
- Хэрэг гарсан, он,сар, өдөр,цаг, хаана гарсан
- Хохирогчийн нас барсан, гэмтсэн шалтгаан,
- Ямар зэвсэг хэрэглэсэн

# Гэмт хэргийн сурвалжлага

Зайлшгүй байх мэдээлэл

- Хэргийн сэдэл
- Боломжтой бол хохирогчийн талаарх зарим мэдээлэл
- Өмчийн эсэрг гэмт хэрэг бол хохирлын хэмжээ, ямар аргаар үйлдэгдсэн
- Сэжигтэн ( албан ёсоор татагдаагүй бол нэрийг бичихгүй), таамаглал
- Цагдаагийн ажилтан, хориогч, гэрчүүдийн яриа
- Мэдээллийн эх сурвалж

# Шүүхийн сурвалжлага

Зайлшгүй байх мэдээлэл

- Шүүгдэгчийн нэр, хаяг
- Сонсгож буй ял
- Хэргээ хүлээсэн эсэх, тийм бол шинээр сонсгосон ял
- Гэмт хэрэгийн шинж чанар, хэргийн талаарх мэдээлэл
- Шүүх хуралдааны тойм
- Шүүхийн нэр
- Шүүгчийн нэр
- Шүүх танхимын ерөнхий зураглал

# Хүний нэр төрд халдахаас сэргийлэх

- Хүний нэр төрийг гутааж болзошгүй бүх бүх мэдээллийг шалгах, ялангуяа:
  - Тухайн хүн ажлаа хийж чадах эсэхэд эргэлзсэн
  - Ямар нэг гэмт хэрэг үйлдсэн, эсвэл сэжиглэгдсэн
  - Тухайн хүнийг оюун саннаны хомсдолтой, эсвэл яман нэг жигшмээр өвчин туссан
- Эргэлзээтэй материалыг баталгаатай болгох
- Баричлагдса, хохирол учруулсан, эрүүгийн хэргийн талаарх мэдээлэлд онцгой анхаарах
- Довтолгоо, батлагаа, өөрийгөө хамгаалж буй мэдэгдлүүдийг сайтар нягтлах
- “Мэдээлж байгаагаар бол”, “яригдаж байгаагаар бол “ гэх мэт үгсийг шургуулах гэж оролдох хэрэггүй
- Довтолгоо, эрс буруушаалтад өртөж буй хүн дээр очиж шалгах
- Доромжилсон үг хэлллэгийг онцгой анхаарах

# Хүний нэр төрд халдахаас сэргийлэх

Сэдэв	Аюултай үгс
Гэмт хэрэг	Луйварчин, хулгайч, гангстер, тонуулчин, акул, мэргэжлийн гэмт хэрэгтэн гэх мэт
Ажил мэргэжлээ зохисгүй хийх	Чадваргүй, бүтэлгүй, ёс зүйгүй хуульч, юу ч мэдэхгүй, тэнэг, сэтгэдэгүй гэх мэт
Бусад харилцах боломжгүй болгодог өвчин	Архичин, донтон, ДОХ-той гэх мэт
Хүний чадварыг үгүйсгэх	Найдваргүй, дампуу, залилан мэхлэгч гэх мэт
Бэлгийн харьцаа	Янхан, хормойн донтой, завхай, завхарсан гэх мэт
Оюун ухааны чадваргүй	Солиотой, ухаанд нь ухна ишиг шүгэлсэн, сэтгэл мэдрэлийн өвчтэй, шизотой гэх мэт
Тохуурал басамжлал	Луйварчин, фашист, коммунист, хулчгар, хоёр нүүртэн, казах хүн өөдгүй, дөрвөд хүн биш гэх мэт

# Хүний нэр төрд халдахаас сэргийлэх

- Үзэл бодлоо бүү тулга
- Цагдаа, шүүхийн ажилтны албаны гадуур өгсөн мэдээллийг болгоомжтой хэрэглэх
- Үнэн л хамгаалалт болдог. Сайн санаагаар, сэрэмжлүүлэх гэж бичсэн гээд нэмэргүй
- Алдаагаа хүлээх нь хамгаалалт биш

# Алдаанаас сэргийлэх нь

Лоуренс Бопре- Уэстчестер Рокланд  
Нюспейперз, Нью Уорк

- Бүх мэдээлэлд эргэлзээтэй ханд
- Эх сурвалжтай болгоомжтой харилц
- Нарийн түвэгтэй материал дээр ажиллахдаа баримт сэлт, ишлэлийг анхдагч эх сурвалжтай харьцуулан хоёр дахин шалгаж, зөв ойлгосон эсэхээ баталгаажуул

# Алдаанаас сэргийлэх нь

- Бүү таа. Овог...
- Бичлэг хийх чадвараа сайжруул
- Намын сангийн материал сайн ашиглах, гэхдээ сонины материалд болгоомжтой ханд
- Материалынхаа эцсийн хувилбарыг дахин анхааралтай унш
- Хамгийн гол нь: Буруутсан бол алдаагаа хүлээн зөвшөөр

# Алдаанаас сэргийлэх нь

Дэвид Рэндалл: “Ховор сэтгүүлч”

- Ямарваа үнэ цэнэ агуулсан баримт бичгийг цуглуул, сайн хадгал
- Хуучин эх сурвалжаа эргэж шалга
- Ямар нэг нууц үйл ажиллагаа эхлэхээсээ өмнө арав дахин бод.Хууль бус ажил аюул дагуулдаг
- Нууц байдал өөрөө худал хуурмагтай хутгалддаг тул илчлэгдэх нь ноцтой байдалд хүргэнэ. Шударга бус үйлдлийг цагаатгахад хэцүү
- Гэмт хэргийг нууцаар эрэн сурвалжилснаар хууль бус үйлдэлд татагдан орж болзошгүй. Энэ нь таны үйлдлийг цагаатгахад бүр хүнд байдалд хүргэнэ
- Ийм нөхцөл амь биед эрсдэлтэй. Айдас, мэдрэмж салахгүй уддаг. Амиа алдсан сэтгүүлч юу ч бичихгүй
- Мэдээлэл авахын тулд хээл хахууль өгөх ёсгүй

# Асуулт яаж тавих вэ?

Юлия Шум:

- Зорилт, хүрээгээ тодорхойл: Яг юу сонсохыг хүсэж байна вэ?
- Асуултаа бэлтгэ. Үндсэн, нэмэлт, анхны, завсрын, бататгах, тодруулах, нарийвчлах, сануулах, шалгах асуулт
- Тодорхой, ойлгомжтой томъёолох. Энгийн асуулт дээр. Тааварласан хариултаас зайлсхийх асуулт байх

# Асуулт яаж тавих вэ?

- Тавих асуулт өөртөө мэдээлэл агуулсан байдаг. Иймд тухайн сэдэв, асуудлаар өөрөө хэр зэрэг бэлтгэлтэйгээ ямар түвшинд харуулах вэ гэдгээ шийд
- Хүссэн хүн тантай ярилцах дургүй бол яах вэ?
  - Болж өгвөл шалтгааныг нь олохыг бод.
  - Сониуч занг нь хөдөлгөхүйц мэдээлэл байгаа хэл
  - Саруул ухаанд нөлөөхүйц, нийгмийн ач холбогдлыг ойлгуулахыг хичээ
  - Тусламаар байвч санахгүй байгаа хүнээс бол дурсамжийг нь хөтлөхүйц асуулт тавь

# Яриагаа яаж эхлэх вэ?

- Эхлээд хаана ярилцахаа бод
- Яриа эхлэх эхний үг, өнгөө сайн бод
- Өөрийгөө танилцуулаад, ярилцах хүнийхээ овог нэр, ажлын газар, албан тушаал, зэрэг дэвийг тэмдэглэж ав
- Тухайн хүн өөрт чинь тааламжгүй санагдсан бол бүү мэдэгд
- Бүү түгдэр
- Шууд зөрчилд хүргэхээр яриагаа эхэлж болохгүй

# Биеэ хэрхэн авч явах вэ?

- Сөрөг нөлөө үзүүлэхүйц байдал бүү гарга
- Найрсаг байж, сэтгүүлчийн мэргэжлээрээ далайлгах хэрэггүй
- Яриа эхлэхийн мнө өөрийн зорилго, бичих гэж буй материалын тухай танилцуул
- Ярилцагчаа өөртөө дасга
- Туханй хүний намтрын ач холбогдол бүхий хэсгийн тухай мэдэж бай
- Нүд рүү нь эгцлэн бүү удаан ширт
- Хувцсаа тохируул
- Мэдээлэл өгөх гэж буй хүний оронд өөрийгөө тавьж үз
- Ярилцагчийнха сайн талд тулгуурлан ярилцахыг хичээ
- Диктофонаа шууд гаргаж тавьсны хэрэггүй

# Худлаа ярьж буйг хэрхэн мэдэх вэ?

- Нэг шалтгааныг хэд хэдэн янзаар тайлбарладаг
- Яриа нь тодорхой бус, ерөнхий, бүрхэг
- Сэтгэл хөдлөл ядмаг, дүрслэл бага
- Өөригөө зарчимч, шударга хүн болохыг байн байн батлах гэж хичээдэг
- Шууд асуултаас бултдаг
- Мэдэж байгаа баримт мэдээллээс илэрхий нуудаг

# Мэргэжлийн ёс зүй

Хариуцлагатай сэтгүүл зүйн соёлыг хэвшүүлэх нь сэтгүүл зүйн үйл ажиллагааг эрхэлж буй редактор, сэтгүүлч, сурвалжлагч, хэвлэл мэдээллийн байгууллагын бусад мэргэжилтнүүдийн өөрийнх нь ертөнцийг үзэх үзэл, иргэний байр суурь, итгэл үнэмшил, мэдлэг боловсрол, хүмүүжил ёс суртахуунтай ихээхэн холбоотой. Үүний зэрэгцээ мэргэжлийн ёс зүйгээ дээдлэх нь сэтгүүлчийн эрхэм үүрэг юм.

# Ёс зүй

Ёс зүй: ёс суртахуун , ёс журам

- Ёс суртахуун: зан суртахуун, хүмүүжил
- Ёс журам: биеэ авч явах байдал, үйлдэл

Ёс зүй нь сэтгүүлчийг хүнд ухаалаг, шударга хандахыг шаарддаг. Ёс зүйд үүрэг хариуцлага, хүний мөс, хүн чанар, амьдралын утга учир гэх зэрэг олон асуудал хамаарагдана.

# Ёс зүй

## Албаны ёс зүй:

- Сэтгүүлчийн мэдлэг чадваргүй, сул доройгоор дамжин орж ирж болох хувийн болон бусад явцуу сонирхлоос хамгаалах хяналтыг тогтоох хэм хэмжээ

## Мэргэжлийн ёс зүй:

- Мэдлэг, мэргэжилдээ үнэнч байж, хувийн эрх ашгийг огоорон, мэргэжлийн нэр хүндээ хамгаалж, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсарлан үүргээ чанд биелүүлэхийн төлөө тогтоосон хэм хэмжээ

# Хувийн нууц



- Хувийн зүйлийг ил болгох
- Хувийн орчинд нэвтрэх
- Худал материал нийтлэх, нэвтрүүлэх
- Зорилгодоо ашиглах

# Хувийн ёс зүйн зарчим

- Алдаагаа хүлээн зөвшөөрөх хүсэл эрмэлзэлтэй байх
- Өөрөө хүлээн зөвшөөрөхгүй байсан ч баримтад тулгуурлах шийдвэр төгс байх
- Үнэнийг хэлэхэд саад болж буй магтаал, мөнгө, алдар цуу, эрх мэдлийг эсэргүүцэх
- Зовлон шаналалд энэлсэн хүнийг ойлгох
- Нийгмийн бүх гишүүдийн илүү таатай аж байдалд хувь нэмэр оруулах
- Шударга бус зүйлийг эсэргүүцэх

# Хүүхдийн асуудлыг сурвалжлах нь

- Олон улсын сэтгүүлчдийн холбоо, 1998 оны 5-р сарын 2, *Бразилийн Ресифе хоть Их хурал*
- “ Хэвлэл мэдээлэл ба хүүхдийн эрх” бага хурал
- " Хүүхдийн эрхийг сурвалжлахад баримтлах зарчим “ - ын төсөл
- 2001 он, Сөүл хот, Их Хурлаараа баталсан билээ.

# Хүүхдийн асуудлыг сурвалжлах нь

- Энэхүү зарчим нь хүүхдийн эрхийг хамгаалах үйлст сэтгүүлчдийн нийтээр даган мөрдөх нийтлэг хэм хэмжээ бий болгох, энэ талаар хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүдийн ухамсрыг дээшлүүлэх зорилготой

# Хүүхдийн асуудлыг сурвалжлах нь

Зарчмын 4-р зүйлд: " Хүүхдийн асуудлыг сурвалжлахдаа ёс зүйн өндөр зарчмын үүднээс хандана" гээд тухайлбал:

- Хүүхэдтэй холбоотой асуудлыг сурвалжлан тавихдаа туйлын хянамгай, мэдрэмжтэй байх
- Хэвшмэл ойлголтоос зайлсхийх, нийтлэл, материалынхаа тусын тулд сенсаци хөөцөлдөхгүй байх
- Хүүхэдтэй холбоотой аливаа нийтлэлийн үр дагаврыг сайтар бодож тооцоолон хүүхдэд учирч болзошгүй хор хохирлыг багасгах
- Зайлшгүй шаардлагатай бус бол хүүхдийн зураг, дүрсийг үзүүлэхийн хэрэггүй бөгөөд ярилцлагад өөр нэр ашиглах
- Боломжтой үед хүүхдүүдэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр үзэл бодлоо илэрхийлэх боломж олгох. Ингэхдээ дэргэд нь дарга, удирдлагыг байлгахгүй байх
- Хүүхдийн өгч буй мэдээлэл нь хараат бус байх баталгааг хангах, гэхдээ мэдээлэл өгснөөр хүүхэд золиосонд өртөхгүй байх талаар онцгой анхаарал тавих
- Хүүхэдтэй сексийн тухай төсөөллийн талаар ярилцахаас зайлсхийх
- Хүүхдийн зургийг авахдаа шударга арга хэрэглэх, Боломжтой үед өөрт нь мэдэгдэж, зөвшөөрөл авах. Эсвэл хүүхдийг хариуцаж буй насанд хүрэгсэд, хамгаалагч, асрагчаас зөвшөөрөл авсан байх
- Хүүхдийн нэрийн өмнөөс ярих, эсвэл хүүхдийн ашиг сонирхлыг төлөөлж буй аливаа байгууллагын зөвшөөрөл, бүртгэлийг шалгах

## *Хүчирхийллийн асуудлыг сурвалжлахад юу анхаарах вэ?*

- Үнэнийг эрхэмлэ
- Хүчирхийлэл бодит үзэгдэл гэдгийг ямагт сана
- Бусдын хүний эрхийг хүндэтгэ
- Хүчирхийлэл бол далд баримт тул эрэн сурвалжлах сэтгүүл хэрэгтэй.
- Гэр бүл дэх хүчирхийлэл нь онцгой мэдрэмж, хэлхээ холбоотой хамаатай
- Хүүхдүүд гэр бүлийн гишүүд гэдгийг хэрхэвч мартаж болохгүй.

# *Хүчирхийллийн асуудлыг сурвалжлахад юу анхаарах вэ?*

- Сэтгүүлчийн мэргэжлийн үүрэг, ёс зүйн шалгуур
- Өнцгөө зөв тодорхойл
- Мэдээлэл хараат бус байх
- Эх сурвалж заавал шаардлагатай
- Түгээх, дэлгэрүүлэхийг бүү яар
- Сэрэмжлүүлэх нь чухал

# Хүчирхийлэлд өртөгчтэй ярилцлага ХИЙХДЭЭ:

- Хохирогчтой ижил түвшинд хандаарай. Өөрийгөө дээгүүр, эсвэл доогуур бүү тавь,
- Битгийн өрөвд, битгий буруутга, битгий шүүмжил.
- Ярилцлага авахдаа ярилцлагын зорилго, ярилцлагааас гарах эерэг, сөрөг үр дагаврын тухай урьдчилан ойлголцохыг хичээгээрэй
- Таны оронд хэн ч байсан ийм байдалд орж болзошгүй байсныг илэрхийл. Тэвчээртэй, тайван байж, боломжтой бол бухимдлаа тайлахад нь тусалж,
- зөвлөөрэй.
- Яагаад гэдэг асуултаас аль болох зайлсхий. Бусад эх сурвалжтай чухал асуудлаар ярилцаж байхдаа тавьдаг энэ асуулт хүчирхийлэлд өртөгчийн хувьд
- тийм ч чухал байдаггүй байна.
- Хохирогчийг дэмжиж байгаагаа гаднах төрх, нүүр царай, хандлага, байгаа байдал, үгээрээ илэрхийл.
- Хувийн нууцыг нь хадгална гэдгээ батлаарай. Хохирогч өөрөө зөвшөөрөөгүй тохиолдолд илт танигдаж болох шинж, содон тэмдэг, болсон үйл явдал, газрыг өөрчлөн бичиж болох эсэхийг зөвшилц. Энэ нь хохирогч танигдаж болзошгүй байдлаас зайлсхийж буй хэрэг боловч ер нь эхнээсээ энэ тухай нийтэлж, нэвтрүүлж болох тухай тохиролцох нь дээр.
- Хохирогч зөвшөөрсөн байлаа ч ярилцлагыг нийтлэх, нэвтрүүлэхээс өмнө өөрт нь үзүүлэх, сонсгохыг хичээгээрэй.
- Хохирогчоос өөрөөс нь зөвшөөрөл аваагүй бол бусдад нууцыг нь бүү дэлгэ.
- Ярилцлагын төгсгөлд хохирогчийн сэтгэлийг засч, дэмжсэн эерэг үг заавал хэлээрэй.

# Institute for Mental Health Initiatives (IMHI)- Оюуны эрүүл мэндийн санаачилгын институт

Хэвлэл мэдээллийн боломж:

- Учир утгагүй хүчирхийллийг үзүүлэхгүй байх
- Уран бүтээлийн баатрууд аюул аймшгийн өөдөөс хүч хэрэглэхээсээ илүү ухаанаар тэмцэж буйг түлхүү харуулах.
- Харгис хэрцгий этгээдүүдийн өөрийн ухаангүй, бодлогогүй үйлдэлд буруутайгаар хэрэглэж буй буу зэвсгийг аль болох бага үзүүлэх.
- Буруутай этгээдүүдийн үйлдсэн гэр бүлийн хүчирхийллийн хор уршиг, сэтгэл санаа, нийгмийн үр дагаварыг буруу гэж ойлгохоор харуулж, ялангуяа хүүхэд залуучуудад жигшин зэвүүцэх сэтгэл төрүүлэх, муу, зохисгүй үйлдэл гэдгийг ухамсарлуулах чиглэл барих.

## *Хүчирхийлэл үйлдэгчтэй ярилцлага хийхдээ:*

- Хүчирхийлэл гэмт хэрэг учраас хүчирхийлэгчид өөрийг нь дэмжиж буй сэтгэгдэл төрүүлэхүйц үйлдэл бүү хий. Бас жигшин зэвүүцэж буй байгаагаа ч илэрхийлэх хэрэггүй
- Учир шалтгааныг олохыг хичээгээрэй. Хүчирхийлэл үйлдэгч худлаа ярьж байна гэж бүү бодоорой. Шинэ баримт ч гаргаж ирж болно.
- Чөлөөтэй ярих, тайлбарлах боломж олгож, итгэл олохыг чухалчил. Болж өгвөл яриагий нь бүү тасал.

## ОУСХ-ны “Сэтгүүлчдийн баримтлах зарчим

- “Үнэнийг эрхэмлэж, үнэнийг мэдэх гэсэн олон түмний эрхийг хүндэтгэх нь сэтгүүлчийн нэн тэргүүний үүрэг мөн
- Мэдээллийн хэрэгслээр дэвэргэсэн ялгаварлан гадуурхалт ямар аюултайг сэтгүүлч ухамсарлаж, улмаар арьсны өнгө, хүйсийн ялгаа, хэл, шайшин шүтлэг, улс төрийн юм уу, өөр үзэл бодол, үндэс угсаа, нийгмийн гарлаар болон бас бус шалтгаанаар ялгаж гадуурхахаас сэрэмжлэхийн төлөө чадах бүхнээ хийнэ

# Сэтгүүлчийн мэргэжлийн ноцтой алдаа

- Бусдыг бүтээлийг хулгайлах
- Юмыг санаатайгаар мушгин гуйвуулах
- Бусдыг гүтгэх, нэр төрийг нь гутаах, элдийн нэр хоч өгч, доромжлох, хүнийг ор үндэсгүй буруутгах
- Юмыг нийтлэх эсэхийг шийдэхдээ аливаа хэлбэрээр хээл хахууль авах

# Хувь хүнийг хүндэтгэ

- Хүнийг сэвтээсэн мэдээ тараах нь нийгмийн ашгаас үүдэлтэй бус бол түүнийг нийтэлж, хувийн халдашгүй байдалд бүү халд.
- Гэр бүлийн будлиан, асран хамгаалагчтай холбоотой мэдээллийг тараах эсэхээ шийдэхийн өмнө шалтаг шалтгааныг найрийн тунгааж, сайн бод. Ойр орчныхонд нь хор хүргэж болзошгүй
- Амиа хорлосон, амиа хорлохыг завдсан тухай мэдээлэхдээ өнгө аясыг нь сайн бод. Төрөл төрөгсдийнх нь сэтгэл санаа, хувийн халдашгүйбайдлыг бүү март
- Гэмт үйлдлийн золиос бологсдын тухай мэдээлэхдээ туйлын болгоомжтой ханд. Тэдний байдал хүнд байгааг бүү март

# Хувь хүнийг хүндэтгэ

- Учир холбогдол багатай, бараан саарал өнгө аястай мэдээлллийн гарчиг, тодтгол зэрэгт тухайн мэдээлллийн “баатрууд”-ын уг гарвал, арьсны өнгө, яс үндэс, хүйсийг бүү онцлон тэмдэглэ. Эрхэлж буй албан тушаал, улс төрийн үзэл бодол, шашиг шүтлэгийн тухайд ч мөн энэ зарчмыг мөрд
- Фото зураг, видео бичлэгт хүнийг гомдоох, сэтгэл санаагаар унах, гутралд орохоос зайлсхий
- Фото, видеогийн эвлүүлгийн агуулга, утга санааг бүү гуйвуул. Хуурамч зургийг жинхэнэ мэт бүү үзүүл. Хуучин зургийг одоогийнх шиг, эсвэл саяхны мэтээр бүү харуул

# Хувь хүнийг хүндэтгэ

- Мэдээллийнхээ үнэн зөвд итгэлгүйгээр гэмт хэргийн тухай бүү нийтэл
- Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн нэрийг ил тодоор бүү зарла
- Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тухай бичихдээ ялын тогтоолыг л мэдээл. Дүгнэлт хийх гэж бүү яар.
- Хүний нэр усыг дурдахдаа түүнд гэм хор хүргэх эсхийг нарийн нягт цэнэ. Олон нийтийн эрх ашигтай холбоогүй бол нэрийг орхи. Гэмт хэрэгт сэжиглэгдсэн, ял шийтгүүлсэн хүмүүст ч энэ хамаатай
- Хүний нэрийг нийтлэхээс татгалзахдаа нүр царайг бүү үзүүл, мөн ажлын газар, нас хүйс, яг үндэс зэрэг түүнийг хүмүүс таниж болох бусад шинжийн тухай мэдээллийг бүү өг
- Гэмт хэрэг үйлдсэн хүн түрүүнд нь ял шийтгэл хүлээж байсан тухай шаардлагагүй бол бүү мэдээл
- Эрэн сурвалжлагдаж байгаа хүмүүсийн тухай баримтыг анхааралтай шалга

# Дарамт шахалтаас өөрийгөө сэргийл

- Редакцаа ажилладаггүй хүмүүсээс бүү даалгавар ав
- Тийм хүмүүсээс бэлэг сэлт, үнэгүй аялах урилга зэргийг бүү хүлээн ав
- Сэтгүүлчийнхээ статусыг хэн нэгэнд дарамт шахалт үзүүлэх зорилгоор бүү ашигла
- Аливаа нийтлэгдээгүй материалыг хувийн, эсхүл бусдын ашиг сонирхлын үүднээс бүү ашигла
- Ярилцлага, гэрэл зураг, бичлэгийг хэзээ ч хуурамчаар бүү үйлд
- Гэмт хэрэг, золгүй явдалтай холбоотой зураг, бичлэгийг нягт нямбай шалга
- Бүх материалын зохиогчийн эрхийг хүндэтгэ

# Дарамт шахалтаас өөрийгөө сэргийл

- Таны материал бусдын мэдлэг, баримтад тулгурласан бол эх сурвалжийг бүү нуу
- Өөрийн итгэл үнэмшилд харш зүйлийг бүү бич
- Тухайн материалыг бичих нь өөрт тань доромжлол, басамжлал мэт санагдвал татгалз
- Өөрийнх нь санаа бодлыг хаана, ямар хэлбэрээр нийтлэх, нэвтрүүлэхийг урьдчилан хүссэн хүмүүсийг угтан тос
- Ярилцлага өгч дадаагүй хүмүүст анхааралтай ханд. Нийтлэх, нэвтрүүлэх, эсвэл мэдээлэл цуглуулж буй алин болохыг тайлбарлан хэл

Анхаарал тавьсанд баярлалаа



[www.globeinter.org.mn](http://www.globeinter.org.mn)

[www.upr-mongolia.mn](http://www.upr-mongolia.mn)